Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА ДАНГААГИЙН БАЯРБОЛДЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1: "Зонхилон тохиолдох халдварт өвчний хяналт, сэргийлэлт, хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилт, зохицуулалт" зорилтын хүрээнд							
1.	ЗГҮАХТ 2.3.1.2 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.14 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх. (2022-2025)	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн.	2025 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 8 зорилтын хүрээнд 135 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 40%-тай байна.	2025.01.01 2025.12.31	100% ✓
2.	ЗГҮАХТ 2.3.1.2 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2 үе шаттайгаар үнэлэх	Үнэлгээний тайлан	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-тэй хамтран үнэлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөний өөрийн үнэлгээг хийх тухай Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 2/555 тоот албан бичгийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-д тус тус хүргүүлсэн. Дээрх гурван байгууллагаас ирүүлсэн өөрийн	2025.01.01 2025.12.31	100% 50. Беловерруулж ирсэн.

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					үнэлгээний үр дүнг нэтгэн боловсруулж байна.		
3.	ЗГҮАХТ 2.3.1.2 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" 2026-2029 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах	Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал	Арга хэмжээний төлөвлгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх 2026-2029 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тушаалын төслийг боловсруулж байна.	2025.06.01 2025.12.31	30%
4.	АХ-2050, зорилт 2.2.1 МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ 2.3.1.1. Арга хэмжээ 1.1. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгуулах техникийн ажлын хэсгийн удирдаж ажиллах	Үндэсний хэмжээний төв байгуулагдах эрхзүйн орчин бүрдсэн байна.	-	Техникийн хэсгийн хурлыг зохион байгуулж, холбогдох судалгаа хийсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/44 дүгээр тушаалаар Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Удирдан чиглүүлэх баг, 2 техникийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Техникийн ажлын хэсгийн 5 чиглэл 23 заалт бүхий нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Удирдан чиглүүлэх багийн хурлыг 2 удаа зохион байгуулж (2 дахь хурлыг ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтарсан байдлаар) хурлын шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллаж байна. НЭМАХҮТ байгуулахтай холбоотой тусгай мэргэжлийн төвүүдээс татагдан ажиллах хүний нөөцийн судалгааг албан тушаалын тодорхойлолтод үндэслэн гаргасан. НЭМАХҮТ-ийн үйл ажиллагааны чиглэл болон бүтцийн зураглалын эхний төсөл гарсан.	2025.01.01 2025.12.31	50%
5.	Арга хэмжээ 3.1 Эрүүл мэндийн аюулгүй байдлын салбар хоорондын үйл	Шадар сайдын тушаал	-	Ажлын хэсгийн тушаал батлуулсан байна.	Улсын онцгой комиссын даргын 2025 оны 02 дугаар тушаалаар 4 яам, 10 байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгийг байгуулан, 3 удаа ажлын	2025.01.01 2025.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах				хэсгийн хурлыг зохион байгуулаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ДЭМБ-ын аргачлалын дагуу Эрүүл мэндийн аюулгүй байдлын салбар хоорондын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах загварыг гарган, төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай суурь бичиг баримтын үнэлгээг хийж байна.		
6.	Арга хэмжээ 3.2 Нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн этгээдийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх өвчний жагсаалт гаргах	Батлагдсан шийдвэр, танилцуулга	-	Тушаалын төсөл боловсруулсан байна.	Хугацаа болоогүй.	2025.06.01 2025.12.31	
7.	Зонхилон тохиолдох зарим халдварт өвчний хяналт-сэргийлэлт-хариу арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Батлагдсан шийдвэр	-	Зонхилон тохиолдох 2 өвчинд суурилсан төлөвлөгөө хийгдсэн байна. - ТТӨ - Менингит	Менингококт халдвар болон Томуу, томуу төст өвчний хяналт-сэргийлэлт-хариу арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг боловсруулаад байна.	2025.01.01 2025.12.31	80% 50
8.	Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол Улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх төслийн	Батлагдсан тушаал	-	Төлөвлөгөөний хэрэгжилт 50%	Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол Улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх төслийн удирдах хороо, техникийн ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/45 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	100% Төлөвлөгөөний хэрэгжилт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хэрэгжилтийг хангах, хурлыг зохион байгуулах (Pandemic fund)				Төслийн удирдах хорооны анхдугаар хурлыг зохион байгуулж, 8 заалт бүхий хурлын шийдвэр гарган хэрэгжүүлж байна.		
9.	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж байгаагүй	Үнэлгээний ажлын хэсэг байгуулна.	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар, Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх аргачлалыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	70%
Зорилт 2: "Дархлаажуулалт болон дархлаажуулалт бүхий халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт" зорилтын хүрээнд							
1.	МУХТЖҮЧ-2.2.1 "Дархлаажуулалтад хэнийг ч орхигдуулахгүй" байх зарчмыг хэрэгжүүлж товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь	2024 оны эхний 11 сарын байдлаар хамралт 94.6 хувь.	2024 оны эхний 4 сарын байдлаар хамралт 90 хувьд хүрсэн байна	Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралт 2025 оны эхний 2 сарын байдлаар 95.1 хувь байна.	2025.01.01 2025.12.31	100%
2.	МУХТЖҮЧ-2.2.1 Дэлхийн дархлаажуулалтын долоо хоногийг угтан олон нийтэд дархлаажуулалтын ач холбогдлын талаар ухуулга, нөлөөллийн аян зохион байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/180 дугаар тушаал	Дархлаажуулалтын долоо хоногийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан байна.	Жил бүрийн 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногийг Дэлхийн дархлаажуулалтын долоо хоног болгон дэлхий дахинд тэмдэглэдэг ба энэ хүрээнд 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн яамны Б зааланд сэтгүүлчид, фэйсбүүк, сошиал медиад олон гишүүдтэй группуудын администрууд зориулсан ухуулга, нөлөөллийн уулзалтыг зохион байгуулсан. Мөн ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 21 аймгийн ЭМГ, нийслэлийн 9 дүүргийн ЭМТ орон	2025.01.01 2025.12.31	100%

Хамрах товлолтоо баталсан уу?

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					нутагтаа "Дархлаажуулалтыг хүн бүрт" уриан дор дархлаажуулалтын өдөрлөг зохион байгуулан ажилласан. Чингэлтэй дүүргийн 1-3-р хорооын Өрхийн эрүүл мэндийн төвд ЭМЯ, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан хамтарсан дархлаажуулалтын ухуулга, нөлөөллийн аяныг зохион байгуулсан. Эрүүл мэндийн сайд, ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч нарын дархлаажуулалтын ололт амжилт, вакцины чанар аюулгүй байдал, ач холбогдлын талаар иргэдэд сурталчилсан видео бичлэгийг ЭМЯ, ДЭМБ болон харьяа байгууллагуудын фэйсбүүк нүүр хуудсаар 4 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд цацсан. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн А/192 тоот "Дархлаажуулалтын 10 хоногийн зохион байгуулах туай" тушаалыг батлуулсан. Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх ХПВ-ийн эсрэг вакциныг нэвтрүүлэх, эцэг эхэд боловсрол олгох кампанит ажлын төлөвлөөг ЭМЯ-ны ЭТБГ-ын даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.		
3.	МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.20 Хүний папилома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх	Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан	2024 онд Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуула	Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 27	"ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын удирдамж"-ыг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т НЭМБГ-ын даргын	2025.01.01 2025.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
		11 насны хүүхдийн эзлэх хувь	лтын хамралтын хувь 25 хувь	хувьд хүрсэн байна.	2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 6/2032 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХПВ-ийн халдварын эрсэг вакцины болон умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх эмч, мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах ажлын удирамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулан нийслэлийн 9 дүүргийн 320 багш, сургуулийн эмч болон дүүргийн НЭ, ЭМТ, хувийн хэвшлийн эх барих, эмэгтэйчүүдийн 80 эмч нарт зориулсан сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 28-30, 5 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх ХПВ-ийн эсрэг вакциныг нэвтрүүлэх, эцэг эхэд боловсрол олгох кампанит ажлын төлөвлөөг ЭМЯ-ны ЭТБГ-ын даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 2025 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 34.8 хувь байна.		
4.	МУХТЖҮЧ-2.2.1 Эрүүл мэндийн сайдын 1997 оны "Журам батлах тухай" А/219 дүгээр тушаал шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 1997 оны А/219 дүгээр тушаалыг мөрдөж ажиллаж байна.	Эрүүл мэндийн сайдын шинэчилсэн тушаалын төслийг боловсруулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 1997 оны А/219 дүгээр тушаалаар батлагдсан "Вакцин, биобэлдмэлийг төлөвлөх, захиалах, зарцуулах, ханган нийлүүлэх журам"-ыг шинэлчлэн боловсруулсан ба газар, хэлтсээр хянуулахаар төлөвлөн ажиллаж байна.	2025.01.012 025.12.31	70%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
5.	Товлолд хүний папилломавирусийн эсрэг вакцин нэвтрүүлсэний дараах үнэлгээг хийх	Үнэлгээний тайлан	-	Үнэлгээний удирдамж гарсан байна.	Монгол Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг товлолд нэвтрүүлэхэд Гави–Вакцин Дархлаажуулалтын Глобал Альянс байгууллагаас 2,6 сая ам долларын буцалтгүй тусламжийг авсан Уг буцалтгүй тусламжийн хүрээнд ДЭМБ-аар дамжуулан Товлолд хүний папилломавирусийн эсрэг вакцин нэвтрүүлсэний дараах үнэлгээг хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгдсөн ажлууд бүрэн дуусаагүйтэй холбоотойгоор хойшилсон. ЭМС-ын 2024 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн гишүүд болон БЗД, БГД, ХУД-ийн ЭМТ, Архангай, Говь-Алтай аймгийн ЭМГ, НЭМ-ийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-ын төлөөллүүд хамтран ХПВ-ийг нэвтрүүлсний дараах түргэвчилсэн үнэлгээг ДЭМБ-ын Ковид-19-ийн үеийн хариу арга хэмжээний үнэлгээний аргачлалын 1.Үндэсний хэмжээний зохион байгуулалт 2.Эрсдэлийн харилцаа гэсэн бүлэг асуумжийн дагуу 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Үнэлгээнээс гарсан үр дүнд үндэслэн "ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын удирдамж"-ыг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулж, аймаг,	2025.01.012 025.12.31	70%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					нийслэлийн ЭМГ-т НЭМБГ-ын даргын 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 6/2032 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
6.	МУХТЖҮЧ-2.2.1 Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх	Үнэлгээний тайлан	2011 онд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн	Үнэлгээний удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.	Монгол Улсад хэрэгжиж буй халдварт өвчинтэй холбоотой зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын удирдамжийг боловсруулан нэгдүгээр хавсралтад Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнгийг тусган Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулан аргачлалын дагуу холбогдох мэдээллийг цугууллахаар ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	100%
7.	Вакцины хадгалалт тээвэрлэлтийн үеийн хэмийн хяналтын үнэлгээг хийх	Үнэлгээний тайлан	-	Үнэлгээ хийгдэж эхэлсэн байна.	Монгол Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг товлолд нэвтрүүлэхэд Гави–Вакцин Дархлаажуулалтын Глобал Альянс байгууллагаас 2,6 сая ам долларын буцалтгүй тусламжийг авч буй бөгөөд уг буцалтгүй тусламжийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангаас Вакцины хадгалалт тээвэрлэлтийн үеийн хэмийн хяналтын үнэлгээг зохион байгуулахаар болсон. 2025 оны 5 дугаар сарын байдлаар ХӨСҮТ, 13 аймгийн 20 дархлаажуулалтын нэгжид 2024-2025 оны өвлийн улирлын хэмийн хяналтын	2025.01.012 025.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					мэдээллийг цуглуулаад байна. 2025 оны оны 6 дугаар сараас эхлэн зуны улирлын мэдээ цуглуулалт эхлэхтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн сангийн зөвлөх Терри Харт ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албатай хамтран 2025 оны 6 сарын 3-ны өдөр үнэлгээний арга зүйн сургалтыг сонгогдсон 13 аймгийн 16 дархлаажуулалтын нэгжийн аймгийн дархлаажуулалт хариуцсан их эмч, хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч нарыг оролцуулан зохион байгуулсан.		
8.	Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 55 дугаар тэмдэглэл ЭМС-ын 2001 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн "Дархлаажуулалтын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 34 дүгээр тушаалыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМС-ын 2001 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн "Дархлаажуулалтын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 34 дүгээр тушаалыг мөрдөж байна.	Эрүүл мэндийн сайдын шинэчилсэн тушаалын төслийг боловсруулсан байна.	ЭМС-ын 2001 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн "Дархлаажуулалтын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 34 дүгээр тушаалыг шинэчлэн боловсруулж, Сэргийлэх тарилга хийхэд харшлах өвчин, эмгэгийн жагсаалтад ЭМЯ-ны дэргэдэх холбогдох мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авахаар ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	70%
9.	Вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн ханган нийлүүлэлтийн ажлыг зохион байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/23 дугаар тушаал	Вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн төсвийн хуваарийг баталж, захиалга хийгдэж эхэлсэн байна.	2025 онд дархлаажуулалтыг зохион байгуулахад шаардлагатай вакцин, зүү тариурын хэрэгцээг Вакцин, биобэлдмэлийн төлөвлөлт, зохицуулалтын хороогоор хэлэлцүүлж, батлуулсны дагуу НҮБ-ын Хүүхдийн санд вакцин, зүү тариурын үнийн санал	2025.01.01 2025.12.31	70%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					ирүүлэх хүсэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/41 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 2025 онд худалдан авах вакцин, биобэлмдэл, зүү тариурын төсөв, хоёрдугаар хавсралтаар Дотоодын ханган нийлүүлэгчээр дамжуулан 2025 онд худалдан авах Вакцин, биобэлдмэл, зүү тариурын төсвийг тус тус батлуулж, ханган нийлүүлэлт хийгдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн А/69 дүгээр "Төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар 2025 онд худалдан авах улирлын томуугийн эсрэг вакцины төсвийг батлуулж, ханган нийлүүлэлт хийгдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/39 дүгээр "Төсөв баталж, санхүүжилт олгох тухай" тушаалаар менингококкт халдварын эсрэг вакциныг худалдан авах төсвийг баталж, ханган нийлүүлэлт хийгдэж байна.		
Зорилт 3: "ХДХВ/ДОХ/БЗДХ, сүрьеэ, гепатитыг тандах, сэргийлэх бодлогын хэрэгжилт, зохицуулалт" зорилтын хүрээнд							
1.	МУХТЖҮЧ-2.2.1 БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028) боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-ний төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	50%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			төлөвлөгөөний зорилт 4				
2.	МУХТЖҮЧ-2.2.1 Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх (2025-2028)	Эрүүл мэндийн сайдын тушаал	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 3	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	"Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө" (2025-2028 он)-ний төслийг боловсруулж батлуулахаар ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна.	2025.01.01 2025.12.31	70%
3.	МУХТЖҮЧ-2.2.1 Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх	Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж байгаагүй	Үнэлгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө батлагдсан байна.	Монгол Улсад хэрэгжиж буй халдварт өвчинтэй холбоотой зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын удирдамжийг боловсруулан гуравдугаар хавсралтад Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг тусган Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулан аргачлалын дагуу холбогдох мэдээллийг цугуулахаар ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	100%
4.	"Эрсдэлт бүлгийн хүн амын дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын	Тандалтын тайлан	-	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	2025 оны 5 сард Эрсдэлт бүлгийн хүн амын дунд ХДХВ/ДОХ, Тэмбүүгийн халдвар, эрсдэлт зан үйлийг тодорхойлох хялбаршуулсан тандалт судалгааны тендер сонгон	2025.01.01 2025.12.31	70% 50

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хялбаршуулсан тандалт" зохион байгуулах				шалгаруулалтыг зарлаж "Эрүүл мэнд форум" ТББ-тай 2025-05-26нд гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2025-12-30-нд дуусах бөгөөд хялбаршуулсан тандалтын ажил үргэлжилж байна. судалгааны ажлын үр дүнг хүлээж авна.		
5.	Сүрьеэгийн илрүүлэг зохион байгуулах журам боловсруулж батлуулах	Батлуулсан журам	ЭМС-ын А/38 дугаар тушаал Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, журам	Журмын төслийг боловсруулан батлуулсан байна.	Эрүүл мэндийн байгууллагад суурилсан сүрьеэгийн илрүүлэг зохион байгуулах журмын төслийг боловсруулан хянаж батлуулахаар ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	50%
6.	НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн тайланг боловсруулж, хүргүүлэх	Хүргүүлсэн тайлан	Жил бүрийн эхний 2 улиралд үнэлгээний тайлан гаргаж хүргүүлдэг.	Тайланг боловсруулж хүргүүлнэ.	2025 оны 3 дугаар сарын 25-29 хооронд олон улсын зөвлөхүүдийг урьж тооцооллыг шинэчлэн гаргаж, "Дэлхийн ДОХ-ын хяналт, шинжилгээ-үнэлгээний тайлан"-д Монгол Улсын тайланг хүргүүлсэн.	2025.01.01 2025.12.31	100%
7.	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-г хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх арга хэмжээний хэрэгжилтийг хувь	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг төлөвлөн 2022-2025 онд хэрэгжүүлж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна.	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025 он)-г 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/577 тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд 11 үйл ажиллагааны чиглэлээр 34 арга хэмжээг 15 шалгуур үзүүлэлттэйгээр төлөвлөсөн. Арга хэмжээний төлөвлөгөө үндэсний хэмжээнд 2023 онд 62.9%, 2024 онд 60.3%, 2025 оны хагас жилээр 61%-ийн хэрэгжилттэй байна.	2025.01.01 2025.12.31	70%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			63%-тай байна.				
8.	Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтан олон нийтэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг хэмжээ зохион байгуулсан байна	"Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийн төлөвлөгөөг хүн амд чиглэсэн сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилааны хүртээмжийг нэмэгдүүлэх, сүрьеэгийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх нь гэсэн үндсэн 2 зорилгийн хүрээнд нийт 47 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд 21 аймагт сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нэгжүүдээр дамжуулан сүрьеэ өвчний тухай сургалт сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажлууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж 2000 гаруй хүнд тараах материал, брошур, видео контент хүргэж ажилласан байна. Сүрьеэгийн илрүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор нэгж бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж ЕБС-ийн сурагчид, оюутан залуус, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амбулаториор үйлчлүүлэгчдийг хамруулсан.	2025.01.01 2025.12.31	100%
9.	Гепатитын эсрэг дэлхийн өдрийг угтан гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг олон нийтэд	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	Гепатитын эсрэг дэлхийн өдрийг угтан гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг,	Хугацаа болоогүй.	2025.01.01 2025.12.31	-

Бэлтгэл хангах хүрэгцүүлсэн гаргасан байна.

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дуусан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хүргэх ажлыг эрчимжүүлэх			мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хангасан байна.			
10.	ДОХ/ХДХВ-тэй тэмцэх дэлхийн өдрийг угтан эмч, эмнэлгийн ажилтан, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан эмч, эмнэлгийн ажилтан, иргэдийн тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	-	Хугацаа болоогүй.	2025.01.012 025.12.31	-
Зорилт 4. "Нийтийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, эрсдэлийн удирдлага, хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилтийн зохицуулалт" зорилтын хүрээнд							
1.	ЗГҮАХТ 2.3.1.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах	Батлагдсан тушаал шийдвэр	Монгол Улсын Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаал	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.	Улсын онцгой комиссын даргын 2025 оны 02 дугаар тушаалаар 4 яам, 10 байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгийг байгуулан, 3 удаа ажлын хэсгийн хурлыг зохион байгууллаа. ЭМЯ-ны Салбарын хяналтын газар, ОБЕГ, ГЕГ, ХӨСҮТ-өөс тушаал өөрчлөх болон нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүлээн авч, засвар хийгдэж байна.	2025.01.01 2025.12.31	? эрүүл ажлыг? Журмыг салбар хоорондоо у/с. ялгах??
2.	Талбарын тархвар судлалын хөтөлбөрийг өргөжүүлэн аймаг, нийслэлийн Шуурхай удирдлагын нэгж болон салбар хоорондын	Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	2024 онд 29 мэргэжилтэнг сургаж, бэлтгэсэн.	Сургалтын удирдамж батлагдсан байна.	Талбарын тархвар судлалын анхан шатны мэргэшүүлэх 2 сарын сургалтын хөтөлбөрийг ЭМЯ-ны дэргэдэх ХӨТСМЗөвлөлөөр хэлэлцүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулсан. Сургалтыг төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын журмын дагуу	2025.01.01 2025.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	мэргэжилтнүүдийг сургаж, чадавхжуулах				суралцагчдыг сонгон шалгаруулж элсэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 1-нд эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		
3.	АХ-2050, зорилт 2.2.10, МУХТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ 2.3.1.1. Арга хэмжээ 1.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн удирдлага зохион байгуулалтын шуурхай байдал, нотолгоонд суурилсан мэдээлэл судалгаагаар хангах нэгдсэн удирдлагын нэгжийн ажиллах журмыг боловсруулах	Нэгдсэн удирдлагын нэгж байгуулах эрхзүйн орчин бүрдсэн байна.	-	-	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/44 дүгээр тушаалаар Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Удирдан чиглүүлэх баг, 2 техникийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Техникийн ажлын хэсгийн 5 чиглэл 23 заалт бүхий нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна. НЭМАХҮТ-ийн үйл ажиллагааны чиглэл болон бүтцийн зураглалын эхний төсөлд Шуурхай удирдлагын нэгжийн бүтцийг тусган оруулсан.	2025.01.01 2025.12.31	50% үнэлгээг оруулахгүй?
4.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1.Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмын төслийг боловсруулах	Журмын төсөл	Журам байхгүй	Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дээр төсөл хийгдэж байна. НЭМТҮТХ-ийн дагуу НЭМАХҮТ байгуулагдсны дараа боловсруулах нь оновчтой. Адаг мөн гэсэн	2025.01.01 2025.12.31	50%

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь

1.	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн НЭМС-д Докторын зэрэг хамгаалах	Хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл	Эрүүл мэнд шинжлэх ухаан сэтгүүлд 2 өгүүлэл хэвлүүлсэн	Web of science and scopus-т бүртгэлтэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл илгээсэн байна.	Frontriers/ Fronters in Public health сэтгүүлд "Distribution of 10-year cardiovascular disease risk levels in Mongolia: results from nation-wide health screening program" өгуулэл хэвлүүлсэн. Volume 13 - 2025 | https://doi.org/10.3389/fpubh.2025.1412262	2025.01.012 025.12.31	100%
2	Улаанбаатар эрдэм их сургуульд хууль эрх зүйн чиглэлээр суралцах	Сургалтад хамрагдсан байна.	1,5 жил эчнээ ангид суралцсан	Эрх зүйчийн мэргэжил эзэмшсэн байна.	"Улаанбаатар эрдэм" их сургуулийн "Эрх зүйч" мэргэжлээр төгссөн. Диплом №6202503135	2025.01.012 025.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	Хариу арга хэмжээний төлөвлөгөө, тайлан	-	Хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна.	Улаанбурхан өвчний дэгдэлт гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/60 дугаар тушаалаар тус өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх Шуурхай удирдлагын багийг томилсон бөгөөд 12 удаа хуралдаж холбогдох байгууллагуудад тухай бүр үүрэг, чиглэлийг өгөн ажиллаж байна. Түүнчлэн 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд улаанбурхан өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх удирдлагын багийг томилон ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Улаанбурхан өвчний эмнэлзүйн заавар батлах тухай" А/81 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Эмнэлзүйн зөвлөх баг ажиллуулах тухай" А/78 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай" А/192 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" 08 дугаар албан даалгаврыг тус тус батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.	2025.02.18 2025.06.31	100%

					Улаанбурханы хариу арга хэмжээг эрчимжүүлэх, нөхөн дархлаажуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 1а/1418 тоот, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 2/2501 тоот, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 6 дугаар сарын бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 14 аймагт дэмжлэгт хяналтын баг ажиллаж, улаанбурхан өвчний хариу арга хэмжээний бэлэн байдал, дархлаажуулалтыг эрчимжүүлэх талаар 240 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад цахим болон ажлын байрны 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, тандалт, ялган оношилгоо, дархлаажуулалтын чиглэлээр 4,325 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. Улсын хэмжээнд улаанбурханы эсрэг товлолын дархлаажуулалтаас хоцорсон болон мэдээлэл нь нөхөн шивэгдээгүй 0-15 насны 231,093 хүүхэд байгаагаас 6 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нөхөн дархлаажуулалтын хамралт 26 хувь, нийслэд 20 хувьтай байна. Улсын хэмжээнд голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 62,455 хүнийг илрүүлснээс 44,290 (81.5%) хүн 72 цагийн дотор дархлаажуулалтад хамрагдаад байна. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А /223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу улаанбурханы эсрэг нэг цэнт вакцинаар товлолын нас болоогүй 6-8 сартай хүүхдүүдийг дархлаажуулж эхлээд байна. Тус тушаалын хоёрдугаар хавсралтаар Улаанбурханы дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг		

					эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.		
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийн ажиллах журам боловсруулах	Боловсруулсан журам	-	Журмын төсөл боловсруулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийн ажиллах журам боловсруулахад шаардлагатай бодлогын баримт бичгийг цуглуулж, шаардлагатай материалыг орчуулсан. Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийн ажиллах журмын эхний төслийг боловсруулсан.		100%
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийн ажилтнуудыг сургах	Сургалтын тайлан	-	Сургалт зохион байгуулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийн ажилтнуудыг сургах 5 хоногийн онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, ЭМЯ болон 10 байгууллагын 35 хүн оролцож, төгсөгчдөд сертификат олгосон.		100%
4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.	Сургалтын тайлан	-	Сургалт зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хариу арга хэмжээ сэдэвт дадлага сургуулилт зохион байгуулах тухай" А/151 дүгээр тушаалын дагуу "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ" сэдэвт онол, дадлага сургуулилтыг 05-р сарын 08-ны өдөр Зоонозын өвчин судлалын үндэсний төвдзохион байгуулсан. "Яаралтай тусламжийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх нь" сэдэвт семинарыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Шангрилла зочид буудалд зохион байгуулав. Сургалтад ЭМЯ-ны харьяа 16 байгууллага болон 21 аймгийн нэгдсэн эмнэлгүүдээс нийт 150 гаруй эмч, эрүүл мэндийн ажилтан оролцов.		100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Халдварт өвчний хэлтсийн дарга — Д.Баярболд / ..... — 2025.06.09

(Албан тушаал) — *(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ОЧИРБАТ

ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Нэг. Үнэлгээ хийх зорилго:

Эрүүл ахуйн тухай хууль 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдаж хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнээс хойш 9 жил өнгөрсөн ч Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно." гэж заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй байна.

Мөн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх нарийвчилсан харилцааг тодорхой зохицуулаагүй, хүндрэл бэрхшээл үүсч байгаа, тус хуулийг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуультай уялдуулан нийцэл, давхардлыг үнэлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, ололт амжилт, хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, салбаруудын оролцоог тодорхойлон цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох, шинэчлэн боловсронгуй болгох үндэслэлийг тогтоож, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Хоёр. Зорилт, шалгуур үзүүлэлт:

2.1.Эрүүл ахуйн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан хууль эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн уялдаа холбоо, тулгамдсан асуудал, бэрхшээлийг тодорхойлох;

2.2.Эрүүл ахуйн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн байдлыг үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл тус бүрээр гаргаж, эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлох;

2.3.Эрүүл ахуйн удирдлагын болон хяналтын тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, бэрхшээлийг тодорхойлох;

2.4.Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангахтай холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангахад салбаруудын оролцооны түвшинг үнэлж, хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тодорхойлох, цаашдын хамтын ажиллагааны цар хүрээг тогтоох;

2.5.Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангахад иргэний дэмжлэг оролцоо, тэдний мэдлэг, хандлагын түвшинд үнэлгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

2.6.Үнэлгээний дүнд үндэслэн Эрүүл ахуйн тухай хуулинд шинэчлэх асуудлыг тогтоох, боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах.

Гурав.Үнэлгээ хийх удирдлага, зохион байгуулалт

3.1.Эрүүл ахуйн тухай хууль эрх зүйн орчны нөхцөл байдал, хуулийн хэрэгжилт, эрүүл ахуйн удирдлагын болон хяналтын тогтолцоо, эрх зүйн баримт бичгүүдэд үнэлгээ хийх багийг томилно.

3.2.Үнэлгээний багт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлөөллийг оролцуулна.

3.3.Томилогдсон баг оролцооны аргаар хэлэлцэн үнэлгээнд хамааруулах хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлал, зөвлөмжийн жагсаалтыг гаргана.

Дөрөв. Үнэлгээг хийх зарчим:

4.1.Эрүүл ахуйн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан эрх зүйн баримт бичгүүдийг хамруулан хийх;

4.2.Үнэлгээг үнэн зөв, бодитой хийх;

4.3.Эрүүл ахуйн тухай хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдсон бүхий л төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг хамруулсан байх.

Тав. Үнэлгээ хийх арга, хэлбэр

5.1.Эрүүл ахуйн тухай хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг тодорхойлохдоо тус хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

5.2.Хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтыг хангах хууль дагаж гарах журам, заавар гарсан эсэх, бусад эрх зүйн баримт бичгийн уялдаа холбооны талаар эрх зүйн баримт бичгүүдийг цуглуулж дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийнэ.

5.3.Эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн болон холбогдох байгууллагуудын тайлан, судалгаа, статистикийн тоо баримт, бусад мэдээллийг албан ёсоор авч, үнэлэлт дүгнэлт өгнө.

5.4.Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдсон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг оролцуулсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулна.

5.5. Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангахад иргэний дэмжлэг оролцоо, тэдний мэдлэг, хандлагын түвшнийг асуумж боловсруулж, цахим санал асуулга /google.form/ -ийг ашиглан авч үнэлгээ хийнэ.

Зургаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

6.1.Ажлын хэсгийн гаргасан жагсаалтын дагуу холбогдох хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлал, зөвлөмжийг нэг бүрчлэн заалт бүрээр шүүлт хийж дараахь чиглэлээр үнэлгээ дүгнэлтийг хүснэгт 1, 2-ийн дагуу гаргана:

6.1.1.Тухайн хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлал, зөвлөмжийг хэрэгжүүлэх бүтэц/механизм үндэсний болон аймаг, сум, орон нутгийн түвшинд бий болсон эсэх;

6.1.2.Тухайн хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлал, зөвлөмжийг хэрэгжүүлэх санхүүгийн механизм байгаа эсэх;

6.1.3.Тухайн хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлал, зөвлөмжийг хэрэгжүүлэх хүний нөөцийн асуудлыг тусгасан эсэх;

6.1.4.Эрүүл ахуйн тухай хуульд заасан батлагдаж гараагүй эрх зүйн баримт бичиг, шалтгаан, үр дагавар;

6.1.5.Тухайн хууль, хөтөлбөр, тушаал, журам, заавар, аргачлалын уялдаа холбоог дараах асуудлаар гаргана. Үүнд:

- Хэрэгжих боломжгүй заалтууд;
- Хэрэгжих боломж хязгаарлагдмал заалтууд;
- Бусад тушаал, журам, заавартай зөрчилдсөн заалтууд;
- Бусад тушаал, журам, заавартай давхцсан заалтууд;
- Ойлгомжгүй буюу тодорхойгүй заалтууд байгаа эсэх;
- Нэмэлт өөрчлөлт оруулсан эсэх, шалтгаан, үр дагавар, шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллага

6.1.6.Заавал хэрэгжих ёстой хэдий ч одоо мөрдөгдөж буй тушаал, журам, зааврууддаар зохицуулагдаагүй орхигдсон асуудлууд байгаа эсэх;

6.1.7.Олон улсын чиг хандлагатай харьцуулан орхигдсон, дутуу тусгагдсан, зөрчилтэй асуудлууд байгаа эсэх;

6.1.8.Тулгамдсан асуудал, бэрхшээл, гарц шийдлийг тодорхойлно.

6.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл тус бүрээр хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагын 2018-2024 оны хяналт шалгалтын тайлан, хяналтын хуудсын нэгтгэлээс хүснэгт 3-ын дагуу гаргана.

6.3.Эрүүл ахуйн удирдлагын болон хяналтын тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, бэрхшээл, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангахтай холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангахад салбаруудын

оролцооны түвшинг үнэлэхдээ 2018-2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд үнэлгээ хийнэ.

6.3.1.Эрүүл ахуйн тухай хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдсон төрийн захиргааны төв байгууллага бүрийн хариуцсан асуудлыг заалт бүрээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд дүн шинжилгээ хийнэ.

6.3.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын Эрүүл ахуйн тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хүснэгт 4-ийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд дүн шинжилгээ хийнэ.

6.3.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Эрүүл ахуйн тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хүснэгт 5-ын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд дүн шинжилгээ хийнэ.

6.3.4. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын Эрүүл ахуйн тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хүснэгт 6-ын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд дүн шинжилгээ хийнэ.

6.4.Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдсон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг оролцуулсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тодорхойлон, цаашдын хамтын ажиллагааны цар хүрээг тогтооно.

6.4.1.Холбогдох байгууллагын төлөөлөлтэй хийх уулзалт, ярилцлагыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- Уулзалт, ярилцлагад үнэлгээний багийн гишүүдийн төлөөллөөс нэг нь ахалж ярилцлагыг удирдан чиглүүлж, 1-2 гишүүн тухайн ярилцлагын тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг бичгээр болон дуу хураах төхөөрөмжөөр хөтөлнө.
- Ярилцлага үргэлжлэх хугацаа дунджаар 30 минутаас 1 цаг байна.
- Эрх зүйн орчны хэрэгжилтийн үйл ажиллагаатай танилцах явцад хийсэн ажиглалтад тулгуурлан нэмэлт асуултууд асууж болно.
- Үнэлгээний баг бүрийн тэмдэглэлд тулгуурлан нэгдсэн тайлан бичихдээ нийтлэг дурьдагдсан давуу, сул талууд боломж болон шийдвэрлэх арга замуудыг нэгтгэн дүгнэх замаар дүн шинжилгээ хийнэ.

6.4.2.Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдсон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан уулзалт, ярилцлага зохион байгуулж, эрүүл ахуйн удирдлагын болон хяналтын тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, бэрхшээл, эрх зүйн баримт бичгийн уялдаа холбоо, эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх, цаашдын хамтын ажиллагааны цар хүрээг тогтооно.

6.4.3.Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын төрөл тус бүрээс санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон хуулийн хэрэгжилтийн байдал, эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй газар дээр нь танилцаж, хавсралт 1-д заасан чиглүүлэх асуултын дагуу, баг бүлгийн ярилцлага зохион байгуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийнэ.

6.5.Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангахад иргэний дэмжлэг, тэдний мэдлэг, хандлагын түвшинг хавсралт 2-д заасан асуумжаар цахим санал асуулга /google.form/ -ийг ашиглан авч үнэлгээ хийнэ.

6.6.Энэ аргачлалын 6.4, 6.5-д заасан уулзалт, ярилцлага, иргэний мэдлэг, хандлагын түвшингийн үнэлгээний дүнг нэгтгэж, дүн шинжилгээ хийн үнэлгээний тайланд тусгана.

6.7.Энэ аргачлалын 6.1-6.6-д тусгасан үнэлгээний тайланг нэгтгэн боловсруулж хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний эцсийн тайланг гаргана.

6.8.Үнэлгээний үр дүнд үндэслэн Эрүүл ахуйн тухай хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэх чиглэлийг тогтоон, боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулна.

6.9.Үнэлгээний нэгдсэн тайланг ерөнхий зүйл, үнэлгээ хийх үндэслэл, шаардлага, зорилго, зорилт, аргачлал, хамрах хүрээ, энэ аргачлалын хоёрдугаар бүлэгт тусгасан зорилт, шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэгдгэн дүн шинжилгээ хийж нэгтгэн боловсруулна.

6.10.Үнэлгээний үр дүн, зөвлөмжийг хэлэлцүүлэх уулзалт оролцогч талуудын төлөөллийг хангасан уулзалт зохион байгуулж, тайланд санал, зөвлөмжийг тусгана.

Үнэлгээнд хамруулах Эрүүл ахуйн тухай хуулийг даган гарсан хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын жагсаалт

Хүснэгт 1

№	Баримт бичгийн нэр	Батлагдсан он, сар, өдөр	Мөрдөгдөж эхэлсэн он, сар, өдөр	Нэмэлт өөрчлөлт оруулсан байдал		
				Он, сар, өдөр	Зүйл заалтын тоо	Зүйл заалтын агуулга

Хууль тогтоомжийн уялдаа холбоо

Хүснэгт 2

№	Баримт бичгийн нэр	Хэрэгжүүлэх механизм бүрдсэн эсэх/тийм, үгүй	Хэрэгжүүлэх санхүүгийн механизм бүрдсэн эсэх/тийм, үгүй	Хэрэгжүүлэх хүний нөөц бүрдсэн эсэх	Хэрэгжих боломжгүй заалт/шалтгаан	Хэрэгжих боломж хязгаарлагдмал заалт	Бусад хууль, журам, заавар, стандарттай давхцсан заалт	Бусад хууль, журам, заавар, стандарттай зөрчилдсөн заалт	Ойлгомжгүй, тодорхойгүй заалт	Зохицуулагдаагүй орхигдсон асуудал

Хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн байдал

Хүснэгт 3

